

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ, ТҮҮНИЙ ХОР УРШИГ

*М. Индрабүд
Магистр*

*Үндэсний батлан хамгаалахын их сургууль
Аюулгүй байдлын дээд сургууль*

peaceg.1210@gmail.com

Хураангуй: Хүн худалдаалах гэмт хэргийг ихэвчлэн зохион байгуулалттай гэмт бүлэг үйлддэг. Зохион байгуулалттай үйлдэгддэг, их хэмжээний ашиг эргэлдэж байдаг тул шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагаас илрүүлж, ял оногдуулах, гэмт хэрэг үйлдсэн хүний гэм бурууг тогтоох нь бусад төрлийн гэмт хэрэгтэй харьцуулахад хүндрэлтэй байдаг. Дэлхийн олон улсад хүнийг бэлгийн мөлжлөгт оруулах, албадан хөдөлмөрлүүлэх, эд эрхтнийг авах зорилгоор үйлдэгддэг хүн худалдаалах гэмт хэрэг нь ашиг орлого хамгийн өндөртэй хууль бус бизнест тооцогдсоор байна. Хүн худалдаалах хэрэг бол зохион байгуулалттай гэмт хэрэг бөгөөд байнгын шинжтэй дамтамжтайгаар үйлдэгддэг. Тиймээс гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцөлийн тодруулах, таслан зогсоохын тулд олон нийтийн оролцоонд тулгуурлан урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар санал зөвлөмж боловсруулах.

Түлхүүр үгс: Хүн худалдаалах гэмт хэрэг /human traffick/, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай бүлэглэл /Transnational organized gangs/, Гэмт этгээдүүд /criminal/, Хүн худалдаалахын эсрэг протокол /Protocol against human traffick/, Эд эрхтний наймаа /organ traffick/, Бэлгийн мөлжлөг /sexual exploitation/

УДИРТГАЛ

Монгол Улс өнөөгийн байдлаар олон улсын хүний эрхийн 50 орчим гэрээ конвенцид нэгдэн орсон. Хүн худалдаалах асуудлыг шууд хөндсөн олон улсын гэрээ конвенциос 1979 оны “Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай” НҮБ-ын конвенцийг 1981 онд, НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай Конвенцид 2000 онд, мөн Конвенцийн “Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оруулахаас сэргийлэх тухай”, “Хүүхдийг худалдах, биеэ үнэлэх, садар самуунд татагдахаас хамгаалах тухай” Протоколуудад 2002 онд, НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2000 онд баталсан “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц”, түүний нэмэлт болох “Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол”, “Шилжин суурьшигчдыг газраар, далайгаар болон агаараар хууль бусаар оруулахын эсрэг протокол”, “Галт зэвсэг, бүрдэл хэсэг, эд анги, галт хэрэгслийг хууль бусаар тээвэрлэх, үйлдвэрлэхийн эсрэг протокол”-д 2008 онд тус тус нэгдэн орсон байна. 2005 онд Монгол Улсын Засгийн газраас “Хүн худалдаалах, ялангуяа хүүхэд эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн

зорилгоор ашиглахаас хамгаалах” Үндэсний хөтөлбөрийг баталж, хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавих Үндэсний зөвлөлийг байгуулсан. 2008 оны Парламентын сонгуулиар эмхлэгдэн байгуулагдсан шинэ Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхтэй холбоотой 2 заалтыг 16 тусгасан байна. Гэвч, хөтөлбөрийг хэрэгжүүлж, бодит үйл ажиллагаа явуулах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг хангалттай гаргах, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч гол байгууллага болох Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам нь идэвхтэй, сайн ажиллахгүй байна. Төр засгаас явуулж буй үйл ажиллагаа нь зөвхөн хурал цуглаан хийх маягаар хязгаарлагдаж байна. Хүн худалдаалахтай тэмцэхэд олон улсын болон гадаадын хандивлагчид 17 голлох үүргийг гүйцэтгэж, санхүүгийн эх үүсвэрийг гаргаж байна. Хандивлагчдын санхүүжилтээр дотоодын төрийн бус байгууллагууд, иргэний нийгмийнхэн голлох үүрэг гүйцэтгэж, нэлээд өргөн хүрээтэй томоохон бодит ажлуудыг хийж байна. Гэвч нийгэмд энэ гэмт хэргийн тоо төдийлөн буурахгүй өсөх хандлагатай байгаа нь цаашид энэ гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцөлийн тодруулах, таслан зогсоохын тулд олон нийтийн оролцоонд тулгуурлан урьдчилан сэргийлэх шаардлагатай байгаа юм.

ҮНДСЭН ХЭСЭГ

Хүн худалдаалах гэмт хэрэг гэдэг хэмээх нэр томъёог 2000 онд НҮБ-ын Ерөнхий ассамблейгаас баталсан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц (НҮБ-ын хүн худалдаалахын эсрэг протокол)-ийн нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилсан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколд тодорхойлсон. Энэ протокол нь олон улсын гэрээ бөгөөд гэрээнд нэгдэн орж, гарын үсэг зурсан бүх улс орон дагаж мөрдөх үүрэгтэй. Хүн, ялангуяа хүүхэд эмэгтэйчүүдийг худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколын 3 дэгээр зүйлд:

- а) Хүн худалдаалах гэдэг нь хүний мөлжих зорилгоор хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, хууран мэхлэх, залилах, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, эсэхүл бусдыг хяналтандаа байлгаж этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуун далдлах буюу хүлээж авах үйлдлийг хэлнэ. Хүнийг мөлжих гэдэгт биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөгт оруулах, албадан хөдөлмөрлүүлэх, боолчлох буюу түүнтэй төстэй нөхцөлд байлгах, эд эрхтнийг нь авах үйлдлийг ойлгоно.

- b) Дээрх аргуудын аль нэгийг ашигласан тохиолдолд хохирогч өөрийг нь а) хэсэгт заасан байдлаар мөлжих гэж байгааг хүлээн зөвшөөрсөн эсэхийг харгалзан хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ.
- c) Мөлжих зорилгоор хүүхдийг элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуун далдлах буюу хүлээж авсан аливаа үйлдэл нь а) хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй хүн худалдаалах гэмт хэрэгт тооцогдоно.
- d) Хүүхэд гэж 18 насанд хүрээгүй хүнийг хэлнэ. ⁸⁹

Хүн худалдаалах гэмт хэргийн зорилго

- Бэлгийн мөлжлөг /хүүхэд, эмэгтэйчүүд/ - хүчээр биеийг нь үнэлүүлэх, секс аялал жуулчлал порнографт ашиглах
- Албадан хөдөлмөрлүүлэх, боолчлох, түүнтэй төстэй нөхцөлд байлгах /хүүхдийн хөдөлмөрийг оруулна/
- Бусад – Эд эрхтнийг авах хүчээр гэрлүүлэх, гуйлга гуйлгах, хууль бусаар хүүхэд үрчилж авах, мансууруулах эм сэтгэцэд нөлөөлөх бодис худалдаалуулах, тээвэрлүүлэх, гэмт хэрэг үйлдүүлэх, циркийн үзүүлбэр зэрэг зугаа цэнгэлд ашиглах

Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэх үе шат

Хүн худалдаалах гэмт хэргийн тайлан, мэдээнд энэ төрлийн гэмт хэрэг өргөн хүрээнд үйлдэгддэг болохыш онцолсон байдаг. Үүнд:

- Хот, хөдөөгөөс хохирогчийг элсүүлэх
- Эх үүсвэрийн газар, тухайлсан газартаа тээвэрлэн хүргэх
- Дамжин өнгөрөх зам, хохирогчийг аваачих
- Эцсийн цэг гэсэн 3 үе шатыг туулдаг байна.

Эрхшээлдээ оруулах

Гэмт этгээд дараах байдлаар хохирогчийг эрхшээлдээ оруулдаг.

Үүнд:

- Хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх
- Хууран мэхлэх, итгэл эвдэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, хяналтандаа байлгаж байгаа хүнд төлбөр төлөх
- Амлалт өгөх, айлган сүрдүүлэх, дарамтлах хулгайлах
- Өрийн дарамтанд оруулах. Өрийн дарамтанд оруулна гэдэг нь унаа тээврийн хөлс, хоол, байр, эрүүл мэндийн төлбөр төлөлт, өдөрт хийх ёстойгоо хийгээгүй учир торгууль төлөх гэх мэт цаг хугацаа өнгөрөхийн хирээр нэмэгддэг ба хохирогч хэзээ ч барагдуулж дуусахааргүй байдаг.

⁸⁹ Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй хянан шийдвэрлэх ажиллагаа: Албан хаагчдыг чадавхижуулах нь. Сургагч багшийн гарын авлага. УБ., 2018 он

- Гэр бүл хамаатан саднаас нь хол байлгаж бусадтай харилцахыг нь хориглож хянаж цагдах
- Иргэний үнэмлэх болон бусад баримт бичгийг нь хурааж авах
- Хохирогч болон түүний гэр бүлийг нь дарамтлах, заналхийлэх
- Гэр бүл, олон нийтэд өөрийнх нь талаар илчилж, нэр төрийг нь гутаана гэж айлган сүрдүүлэх
- Хууль сахиулах байгууллагад мэдэгдвэл шоронд орох эсвэл тухайн улсаас албадан гаргагдана гэж заналхийлэх
- Хохирогчийн мөнгө хувийн эд хөрөнгийг хяналтандаа байлгах
- Хохирогчдын байрлах газрыг ойр ойрхон солих эсвэл нэгээс нөгөөд худалдаалдаг учир ямар газар байгаагаа мэдэхгүй, тусламж хүсэх боломжгүй болгох
- Бие махбдийн болон сэтгэл санааны дарамтанд оруулах замаар өөрөөсөө хараат байдалтай болгох

“Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирсон хохирогчдын шударга ёсыг тогтоох үндсэн зарчмын тухай тунхаглал”-д /1985/ гэмт хэргийн хохирогчийг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

Хохирогч гэж ганцаараа эсвэл олуулаа бие махбодь, сэтгэл санаа, эдийн засгийн хувьд хохирол амсаж, тунхаглалд нэгдэн орсон улс орнуудын Эрүүгийн хуулийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас үндсэн эрх нь зөрчигдсэн хүнийг хэлнэ. ⁹⁰

Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн хүн гэдэг нь:

- Хүн худалдаалах үйл ажиллагаанд ямар нэг байдлаар оролцсон
- Хохирогчийг элсүүлэх, тээвэрлэх, орогнуулах, дамжуулах, хүлээн авах хүртэл бүхий л үйл ажиллагаанд болон хохирогчийг мөлжиж ашиг олох үйл явцад оролцсон этгээдүүдийг хэлнэ.

Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн хүн нь дараах жагсаалтад бүртгэгдсэн аль ч хүн байх боломжтой. Үүнд:

- Элсүүлэгч
- Худалдаалагч
- Худалдан авагч
- Тээвэрлэгч
- Орогнуулагч
- Дамжуулагч
- Хүлээн авагч

⁹⁰ Хүн худалдаалах, бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэрэг. Өмгөөлөгчдөд зориулсан гарын авлага. УБ., 2019 он

- Биеэ үнэлэхийг зохион байгуулдаг газар, тэндээс ашиг хүртэгч, цэнгээний газар, гоо сайхны болон массажны газар зэрэг хохирогчийг ашиглан ашиг олдог газруудыг ажлуулдаг этгээд
- Төрүүлсэн болон үрчлэн авсан, асран хамгаалах харгалзан дэмжих үүрэг хүлээсэн хүний хувьд хүүхдээ санаатайгаар худалдсан, худалдахад хүргэсэн, шилжүүлэн өгсөн эцэг эх, асран хамгаалагч
- Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэх үе шатанд хохирогчийг нуун далдалж, хорж байсан этгээдүүд
- Ажил олгогч / гол ажил олгогч болон гэрээ байгуулагчид/

Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан нөхцөл

Хүн худалдаалах гэмт хэрэг нь дараах шалтгааны улмаас үйлдэгддэг байна.

- Нийгэм, эдийн засгийн
 - Үзэл суртлын
 - Соёл хүмүүжлийн
 - Удирдлага, зохион байгуулалтын
 - Нийгэм, сэтгэл зүйн шалтгаан зэрэг болно.
1. Бага орлого – Төрийн болон төрийн бус байгууллагуудын явуулсан судалгаа хохирогчидтой хийсэн ярилцлага зэргээс үзэхэд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын дийлэнх нь бага орлоготой буюу амжиргаанаас түвшнөөс доогуур амьдралтай бөгөөд тэд амьдрал ахуйгаа сайжруулахын тулд ямар ч хамаагүй аргаар гадаада гарч их мөнгө олох хүсэлдээ хөтлөгдсөн байдаг.
 2. Ажилгүйдэл – Хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан нөхцлийг тодорхойлох зорилгоор явуулсан судалгаагаар цагдаагийн албан хаагч нарын 90%, иргэдийн 87% энэ төрлийн гэмт хэргийн шалтгааныг ажилгүйдэлтэй холбож үзсэн байна. Шүүхээр шийдвэрлэгдсэн болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд байгаа эрүүгийн хэргүүдээс үзэхэд хүн худалдаалах гэмт хэргийг үйлдэгчид нь худалдаалах хүмүүсээ /хохирогчдыг/ ихэвчлэн 10-р анги төгссөн сургуульд орж чадаагүй хүүхдүүд болон дээд боловсролтой мэргэжлийн ажлын хөлсөө голох, улмаар гадаадад гарч их хэмжээний цалин авах сонирхолдоо хөтлөгдөн хүмүүсийг сонгодог болох нь ажиглагдаж байсан. Одоогоор монголоос хичнээн иргэн гарч “хараар” ажиллаж амьдарч байгаа талаар нарийн тоо хэлэх боломжгүй юм. 2002 оны байдлаар АНУ 5000, БНСУ 17000, ХБНГУ 12000, Япон 7000, Казакстанд 67000 гаруй монгол улсын иргэн удаан хугацаагаар оршин сууж байна. Үүний чухам хэд нь эмэгтэйчүүд болох, ямар шугамаар гадаадад гарч ямар нөхцөлд ямар ажил эрхэлж байгаа нь тодорхой бус юм. Манай улсад 2007

оны 12 сарын байдлаар 20-24 насныхан 18306, 25-29 насныхан 38193, 30-34 насныхан 53259, 36-39 насныхан 59145, 40-44 насныхан 50171 хүн ажилгүй байна. Энэхүү тоон үзүүлэлт нь сүүлийн жилүүдэд дэлхий нийтэд болон Монголд нүүрлээд буй эдийн засгийн хямралын улмаас өсч байгаа болох нь хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн, нийгмийн даатгалын сангаас ажилгүйдлын тэтгэмж авч буй иргэдийн судалгаанаас харагдаж байна.

3. Эдийн засгийн тогтворгүй байдал – Эдийн засгийн хувьд буурай, шилжилтийн үедээ буюу хуучин социалист системээс зах зээлийн засагт шилжсэн улсуудын иргэд энэ төрлийн гэмт хэрэгт өртөж, хүн худалдаалах гэмт хэргийн үүр уурхай болжээ хэмээн олон улсын шижээчид үзэж байна. Манай улсын эдийн засгийн өсөлт 2004 онд 10.7%, 2005 онд 6.2%-иар өссөн үзүүлэлт гарсан. Энэ манайхтай ижил эдийн засгийн хөгжилтэй орнуудтай харьцуулахад өндөр үзүүлэлт боловч 2005 оны эдийн засгийн өсөлтийг 2004 оныхтой харьцуулахад 1.8 дахин буурсан байгаа нь манай эдийн засгийн өсөлт тогтворгүй байгааг илтгэнэ. Энэхүү үзүүлэлтийг мэргэжлийн эдийн засагчид мөн ингэж дүгнэсэн байдаг. Монгол улсад 2007, 2008 онд өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт инфляцийн түвшин шууд нөлөөлж, инфляци 2 оронтой тоонтой шилжсэн. Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж буй шалтгаан нөхцөлийг тодорхойлох зорилгоор цагдаагийн албан хаагчид болон иргэдээс дараах шалтгаануудын улмаас гэмт хэрэг үйлдэгдэхэд хүрдэг гэж үзсэн байдаг.

- Эдийн засгийн тогтворгүй байдал
- Ажилгүйдэл
- Ядуурал
- Гадаад улс орнууд болон дотоодод бий болсон нөхцөл байдал
- Биеэ үнэлэх явдал их байгаа
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ доогуур байгаа
- Иргэдийн энэ гэмт хэргийн талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг байгаа
- Иргэдийн өөрсдийн хөнгөмсөг, хялбар аргаар мөнгө олох сонирхол
- Залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх газар цөөн баар, цэнгээний газар их байгаа
- Цагдаа хууль сахиулах байгууллагаас урьдчилан сэргийлэх ажил хангалтгүй явуулдагаас
- Хууль эрх зүйн орчин бүрдээгүй
- Бусад

Гадаад улсуудын болон хөрш орнуудын нөхцөл байдал

АНУ-ын тагнуулын газраас жилд 45-50 мянган охид, эмэгтэйчүүд тус улсруу худалдаалагддаг, мөн хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан орнуудаас баруун европруу жил бүр 600 мянган эмэгтэйг худалдаалдаг. Хятадад жил бүр мянга мянган ядуу амьдралтай, зах хязгаар мужуудын охид, эмэгтэйчүүдүүдийг Тайланд, Тайвань, Япон, Канад, Англи, Америкруу гаргадаг гэж мэдэгдсэн. Олон улсын байгууллага болох Global Survival Network-аас гаргасан илтгэлд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлыг хариуцсан НҮБ-ийн тусгай илтгэгчийн илтгэлээс иш татсанаар “Дэлхийн хэмжээнд 4 сая эмэгтэйчүүдийг хил дамнуулан наймаалж 7 тэрбум долларын ашиг олж байна” гэсэн судалгаа байдаг. Манай улс хөрш БНХАУ-д дотоодод хил давуулан хүн худалдаалах нөхцөл нь:

1. Хууль бус хуурамч зар сурталчилгаа
2. Ядуурал, ажилгүйдэл
3. Гадаадын иргэнтэй гэр бүл болоход зуучлах
4. Хүүхэд үрчлэлт, түүнд тавих сул хяналт
5. Хараа хяналтгүй хүүхдүүд өртөх эрсдэл өндөр
6. Иргэд ялангуяа насанд хүрээгүй хүүхдийг гадаадад зорчиход тавих хяналт дутмаг
7. Хүний эд эрхтнийг донор болгон ашигладаг явдал
8. Хууль бусаар биеэ үнэлдэг эрсдэлт бүлэг зэргээс үүдэн хүний наймаа нийгэмд бий болж байна.

Иймд хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхдээ хүн ялангуяа хүүхэд эмэгтэйчүүдийн эрхийг хангах, энэ эрсдэлд орох хүчин зүйлүүдийг бууруулах, тэдэнд ойр боломжтой байгаа хамгааллын механизмын тоо, чанарыг нэмэгдүүлэхэд оршино. Үүнд:

- Хамгаалах стратеги – энэ чиглэлээр хэрэгжүүлж буй хууль, эрх зүйн бодлого, хөтөлбөрүүд нь хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчдын хамгааллын хэрэгцээнд шууд чиглэсэн байх
- Нөхөн сэргээх стратеги - хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчдод цаашид нийгэмшихэд нь туслах өөртөө болон бусдад итгэх бодол мэдрэмжийг дахин бий болгох, шинээр амьдрах орчинд эргэн нэгтгэх, бие даан амьдрахад нь туслах

Мөн олон нийтэд суурилсан урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулахад тэдний оролцоог хангаж ажиллах явдал чухал юм.

Монгол Улсын эрүүгийн хуулийн шинэтгэлийн хүрээнд УИХ-аас Эрүүгийн хуулийг 2015 оны 12 дугаар сарын 03 -ны өдөр шинэчлэн найруулж, 2017 оны 07 сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдүүлсэн. Энэ хуулийн 13.1 дүгээр зүйлд “Хүн худалдаалах, гэмт хэрэг”-ийг хуульчилсан.

2015 оны Эрүүгийн хуулийн шинэчэлсэн найруулга				
Зүйл, хэсэг	Гэмт хэргийн ангилал	Гэмт хэрэг	Ялын доод хэмжээ	Ялын дээд хэмжээ
13.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	Хүнд гэмт хэрэг	Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд эрхтнийг нь авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулж, эсвэл хяналтандаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж хахуульдаж, хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн, тээвэрлэсэн, орогнуулсан, дамжуулсан, хүлээн авсан	2 жил хорих	3 жил хорих
13.1 дүгээр зүйлийн 2 дэх хэсэг	Хүнд гэмт хэрэг	Хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж, хоёр түүнээс дээш олон хүнийг худалдаалж, Монгол улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн	5 жил хорих	12 жил хорих
13.1 дүгээр зүйлийн 3 дэх хэсэг	Хүнд гэмт хэрэг	Байнга тогтвортой зохион байгуулалттай гэмт хэрэг үйлдсэн	12-20 жил хорих	Бүх насаар нь хорих

2002 он Эрүүгийн хууль		2015 он Эрүүгийн хууль	
Зүйл хэсэг	Оногдуулах ял	Зүйл хэсэг	Оногдуулах ял
113.1 Хүндэвтэр гэмт хэрэг	3-5 жил хорих	13.1 Хүнд гэмт хэрэг	2-8 жил хорих
113.2 Хүнд гэмт хэрэг	5-10 жил хорих	13.2 Хүнд гэмт хэрэг	5-12 жил хорих
113.3 Онц хүнд гэмт хэрэг	10-15 жил хорих	13.3 Хүнд гэмт хэрэг	10-20 жил хорих

Хүн худалдаалах гэмт хэргийг ойролцоох төрлийн гэмт хэргээс ялган зүйчлэхдээ:

<i>13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах</i>	<i>13.2 дугаар зүйл. Бэлгийн мөлжлөг</i>
<p>1. Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд эрхтнийг нь авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулж, эсвэл хяналтандаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж хахуульдаж, хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн, тээвэрлэсэн, орогнуулсан, дамжуулсан, хүлээн авсан бол хоёр жилээс 8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>2. Энэ гэмт хэргийг:</p> <p>2.1. Хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж</p> <p>2.2. Хоёр ба түүнээс олон хүнийг худалдаалж</p>	<p>1. Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>2. Энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор</p> <p>2.1. Арван дөрвөөс арван найман насанд хүрээгүй хүүхдийг албадан оруулж</p> <p>2.2. Урьд энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан бол</p> <p>2.3. Хохирогчид мансууруулах эм, сэтгэцэд нөлөөтэй бодис хэрэглүүлж</p>

<p>2.3. Монгол Улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>3. Энэ гэмт хэргийг:</p> <p>3.1. Байнга тогтвортой</p> <p>3.2. Зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар бүх насаар нь хорих ял шийтгэнэ.</p> <p>Тайлбар: Хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй. Энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход хохирогч нь өөрийг нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар хохироож байгааг өөрөө зөвшөөрсөн эсэх нь гэмт хэргийн зүйчлэлд нөлөөлөхгүй.</p>	<p>2.4. Хохирогчийг жирэмсэн болгож</p> <p>2.5. Хоёр ба түүнээс олон хүний эсрэг</p> <p>2.6. Байнга тогтвортой үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>3. Энэ гэмт хэргийн улмаас:</p> <p>3.1. Ураг зулбасан</p> <p>3.2. Арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>4. Энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлэх ашиг олох зорилгоор:</p> <p>4.1. Бага насны хүүхдийг албадан оруулж</p> <p>4.2. Зохион байгуулалттай гэмт хэрэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар бүх насаар нь хорих ял шийтгэнэ.</p> <p>Тайлбар: Бага насны хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй</p>
---	--

Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх хуулийн байгууллагын 2001-2017 оны статистик мэдээллээс үзэхэд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 113-р зүйлд заасан Хүн худалдаалах /113 дугаар зүйл/ 131 гэмт хэрэг, Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах /124 дүгээр зүйл/ 227 гэмт хэрэг тус тус цагдаагйн байгууллагад бүртгэгдэн шалгагдсан байна.


Он	ХХГХ-ийн ЭХ-ийн /13.1-р зүйл/			Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах /12.6-р зүйл/			ШЕЗ /шүүх/	ХТЭТ-ийн хохирогч
	Хэрэг	холбогдогч	хохирогч	Хэрэг	холбогдогч	хохирогч		
2000	1	1	1	-	-	-	-	-
2001	-	-	-	-	-	-	-	-
2002	8	-	8	0	-	-	-	-
2003	-	-	-	17	-	-	-	3
2004	3	-	3	21	-	-	-	4
2005	2	-	2	30	-	-	1	5
2006	4	10	25	17	4	2	1	13
2007	14	12	22	14	17	17	-	115
2008	42	15	11	9	47	24	2	70
2009	12	21	53	11	12	9	4	81
2010	1	13	18	11	12	7	1	86
2011	6	-	-	15	-	-	2	52
2012	10	-	-	14	-	-	3	51
2013	9	16	34	13	-	-	4	54
2014	8	1		17	8	-	1	49
2015	6	5		28	9	-	2	36
2016	3	8		10	9	-	1	44
2017	12	1	19	35			-	29
2018	8		10				-	39
2019	1		9				-	

2020	3	49	36				1	40
2021	5						4	
Нийт	158	152	251	262	118	59	27	771

2017-2022 оны эхний 7 сар буюу сүүлийн 5 жил гаруй хугацаанд 237 хохирогч тогтоогдсоноос насанд хүрээгүй 95 хохирогч байгаа нь нийт хохирогчдын 40 хувийг эзэлж байна.⁹¹ 2013-2019 онд Хүйсийн тэгш эрхийн төвөөр үйлчлүүлэгчдыг авч үзвэл:



Хохирогчдын 71.5% нь буюу эмэгтэйчүүд байсан ба бэлгийн мөлжлөгт өртсөн байдаг.



ДҮГНЭЛТ, САНАЛ

Монгол Улсад анх 1999 онд хүн худалдаалах гэмт хэргийн тохиолдол бүртгэгдэж байсан бөгөөд түүнээс хойш албадан хөдөлмөрийн зорилгоор ЕвроАзи руу, бэлгийн мөлжлөгийн зорилгоор Бүгд Найрамдах Хятад Ард Улс болон Зүүн Өмнөд Азийн орнууд руу хүн худалдаалах гэмт хэргүүд илэрч байгаа юм. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлд заасан /Хүн худалдаалах/ гэмт хэрэгт 2017-2022 оны эхний 7 сар буюу сүүлийн 5 жил гаруй хугацаанд 237 хохирогч

⁹¹ Бэлгийн мөлжлөгт өртсөн охид, эмэгтэйчүүдэд тусламж үзүүлэх нь. УБ., Хүйсийн тэгш эрхийн төв. Биеэ үнэлэлт болон бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэл. Судалгааны тайлан. УБ., 2019 он

тогтоогдсоноос насанд хүрээгүй 95 хохирогч байгаа нь нийт хохирогчдын 40 хувийг эзэлж байна.

Гэмт хэрэг үйлдэж байгаа бүлэг этгээдүүд ихэвчлэн санхүүгийн хувьд чадамжгүй, нийгмийн эмзэг давхаргын, анхаарал халамж тавих хүнгүй охид, эмэгтэйчүүдийг эзмэг байдлаар нь далимдуулан онилж хохирогчоо болгодог. Тэдэнд хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл хууран мэхэлж, эд хөрөнгө бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ оруулж Монгол Улсад болон гадаадад хүчээр биеийг нь үнэлүүлж, ашиг олж худалдаалдаг байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт мөнгө угаах, хүний наймаа, хар тамхи болон цахим гэмт хэрэг зэрэг шинэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ гэж тусгагдсаны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яам "Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх" үндэсний хөтөлбөр боловсруулан, Засгийн газрын 148 дугаар тогтоолоор батлуулсан байдаг. Засгийн газар нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүчин чармайлт гаргасан хэвээр байна. Эрүүгийн хуулийн 13.1-р зүйлээр хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалахыг гэмт хэрэгт тооцдог болсон. 13.1-р зүйлд хүн худалдаалах гэмт хэргийг насанд хүрсэн хүний эсрэг үйлдсэн бол 2-8 жилийн хорих ял, хүүхдийн эсрэг үйлдсэн бол 5-12 жил хүртэлх хугацаагаар хорих ял оноохоор заасан. Эдгээр ял шийтгэл нь хангалттай чанга бөгөөд бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэргийн ял нь хүчин гэх мэт бусад хүнд гэмт хэрэгт оногдуулдаг ялтай дүйцэхүйц хүнд заалт болсон. Эрүүгийн хуулийн 12.3-р зүйлд бэлгийн мөлжлөгийг гэмт хэрэгт тооцсон бөгөөд үүнд бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах зарим хэлбэрийг мөн хамааруулсан. 12.3-р зүйлд бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэргийг 14-өөс дээш насны хүний эсрэг үйлдсэн бол 2-8 жилийн хорих ял, 14-өөс доош насны хүүхдийн эсрэг үйлдсэн бол 12-20 жил хүртэлх хугацаагаар хорих ял оноохоор заасан. Өмнөх жилүүдийн нэгэн адил эрх бүхий байгууллагаас заримдаа хүн худалдаалах гэмт хэргийг яллахдаа хөнгөн ялаар зүйлчилсэн байна. Төрөөс хууль сахиулах хүн хүч, нөөц бололцоог цар тахлыг тогтоон барихад байнга дайчлах болсон нь зарим тохиолдолд хүн худалдаалахтай тэмцэх хүчин чармайлтыг тасалдуулсан. Энэхүү өөрчлөлтийг эс тооцвол баривчлан саатуулах, мөрдөн шалгах болон шүүн таслах үйл ажиллагаа үргэлжлэн явагдсан. Тайлант хугацаанд төрөөс 49 сэжигтэн холбогдогчтой 36 бэлгийн мөлжлөгийн хэргийг мөрдөн шалгасан (2019 онд 24 сэжигтэн холбогдогчтой 10 хэрэг байсан). Эдгээрээс арван нэгэн хэргийг цагдаагийн байгууллагаас саун, массажны газар, зочид буудал, караоке бар болон биеэ үнэлүүлэх үйл ажиллагаа явуулж байж болзошгүй хэмээх сэжигтэй

газруудад үзлэг шалгалт хийсэн болон нийгмийн сүлжээг ашиглан дээрх агуулгатай зар мэдээлэлд мониторинг хийсний үр дүнд мөрдөн шалгасан байна. Монгол Улс нь урьдчилан сэргийлэлт, хамгааллын арга хэмжээгээ сайжруулах зорилгоор “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр” (2017-2021) болон түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж буй юм. Засгийн газраас энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 2019 онд төсөвлөсөн 509 сая төгрөг (178,610 ам. доллар)-өөр үйл ажиллагаагаа үргэлжлүүлсэн (2018 онд 709 сая төгрөг буюу 248,790 ам. доллар, 2017 онд санхүүжилтгүй байсан). Гэхдээ засгийн газраас энэхүү төсвийн тодорхой хэсгийг цар тахлын эсрэг арга хэмжээ авахад шилжүүлэн зарцуулсан байдаг.

Цаашдаа ч урьдчилан сэргийлэх ажлуудыг идэвхижүүлэх шаардлагатай гэж үзэн дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Олон нийтэд чиглэсэн танин мэдэхүйн шинжтэй мэдээлэл сурталчилгааны ажлуудад хүч тавин ажиллах
2. Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх төрийн зарим чиг үүргүүдийг гэрээгээр гүйцэтгүүлэх төрийн бус байгууллагуудтай хамтрах, харилцан уялдаа холбоог сайжруулах
3. ЕБС-ууд дээр сурагчдад зориулсан хуулийн мэдлэг олгох клуб, дугуйлан хичээлүүлэх, нийгмийн ажилтны оролцоог сайжруулах
4. Эцэг эх, багш, сурагч гурвалсан хамтын холбоог бэхжүүлэх сард 1-2 удаа уулзалт семинарын ажлаар сурагчдыг хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлуудыг төлөвлөх шаардлагатай байгаа юм.

НОМ ЗҮЙ

[1]. Хүүхдийн эрхийн тухай хууль. УБ., 2016 он

[2]. Хүүхэд хамгааллын тухай хууль. УБ., 2016 он

[3]. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль. 2012 он

[4]. Төрмандах.З, Гантулга.С Хүн худалдах гэмт хэрэг .УБ., 2008 он

[5]. Төрмандах.З, Гантулга.С Хүн худалдах гэмт хэрэгтэй гүйцэтгэх ажлаар тэмцэх үндэс.УБ., 2008 он

[6]. Гантулга.С Хүн худалдах гэмт хэрэг .УБ., 2015 он

[7]. Оюунцэцэг.Д Олон нийтийн санаа бодлын социологи. УБ., 2000 он

[8]. Хүн худалдаалах гэмт хэрэг. Гарын авлага. УБ., 2009 он

[9]. Хүүхэд хамгааллын үндэс. Нийгмийн ажилтнууд болон хүүхэдтэй ажилладаг бусад мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлага. УБ., 2009

[10]. Мягмар О. Сэтгэц заслын зөвлөгөөний онол арга зүй. УБ., 2009 он